

**ХҮҮХЭДТЭЙ ШУУД БА ШУУД БУС ХАРИЛЦАН АЖИЛЛАХ УДИРДАХ АЖИЛТАН,  
БАГШ, АЖИЛЧИН, САЙН ДУРЫН ИДЭВХТЭН, ДАДЛАГАЖИГЧ БАГШИЙН  
МӨРДӨХ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

2019 оны 09 дүгээр сарын 18

Улаанбаатар хот

- Хүүхдийн нас, хүйс, нийгмийн гарал үүсэл, амьдарч буй газар нутаг, нийгэм эдийн засгийн байдал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээлээс нь хамаарч тэдэнтэй ялгавартай харьцахгүй.
- Хүүхдэд өөрийн үнэ цэнэ, өөртөө итгэх итгэлийг мэдрүүлэх, түүний өсөлт хөгжил, танин мэдэхүйн үйл явцыг дэмжих, хүүхдийн уламжлалт болон дэвшилтэт хүмүүжлийн аргуудыг сургалт хүмүүжлийн ажилдаа нэвтрүүлж түгээн дэлгэрүүлнэ.
- Сургалт хүмүүжлийн үйл ажиллагааны явцад хүүхдэд сэтгэл санааны дарамт учруулах, үг хэлээр доромжлох, үл хайхрах, бие махбодийн шийтгэл үзүүлэх, бэлгийн сэдэлтэй үг хэллэг, үйлдэл хэрэглэх зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хүргэх эсвэл хүргэсэн байж болзошгүй гэж сэжиглэх аливаа үйлдлийг хийхгүй.
- Сургалт хүмүүжлийн үйл ажиллагаанаас гадуур суралцагчтай хувийн харилцаа холбоо тогтоохгүй.
- Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн “Сургуулийн Хүүхэд хамгааллын бодлого”-ын хүрээнд хүлээсэн үүргээ цаг алдалгүй биелүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад идэвхи санаачлагатай оролцоно.
- Хүүхэд аливаа хүчирхийлэл, дарамт, үл хайхрах байдалд өртөх эрсдлийн тухай ойлголт мэдлэгтэй байж, эрсдэлийн хүчин зүйлийг бууруулах, түүнээс хамгаалах тухай мэдээллийг холбогдох ажилтанд цаг алдалгүй хүргэж хамтран ажиллана.

**Танилцаж, хүлээн зөвшөөрсөн**

..... ажилтай ..... овогтой .....

..... /гарын үсэг/ ..... он ... сарын ....